

## **Петро Матад Лимитед (цаашид “Петро Матад” эсвэл “Компани” гэх)**

### **Давсан Толгой-1 хайгуулын цооногийн талаархи шинэ мэдээлэл**

Петро Матад (AIM:MATD) компани нь Давсан Толгой-1 (DT-1) хайгуулын цооногийн үйл ажиллагааны ахицын талаар шинэчилсэн мэдээллийг хүргүүлж байна.

DT-1 цооногийн өрөмдлөг газрын тосны илэрцтэй Доод Зүүнбаян хэмээх Формацад явагдаж байна. 2010 оны 7 дугаар сарын 12-ны өдөр Доод Зүүнбаян формацын дээд хэсгийн ойролцоо 1075 метрийн гүн дэх 8 метр зузаантай элсэн чулуун бүсэд сайн үзүүлэлттэй нүүрсустөрөгч илэрсэн. Өрөмдлөгийн ажлыг 1093 метрийн гүнд хүрээд өрмийн хошуу солихоор түр зогсоогоод байна.

DT-1 цооног нь Монголын зүүн хэсэгт байрлах XX дугаар талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээний (БХГ) дагуу Петро Матадын 2010 онд явуулах өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд өрөмдөж эхлэх анхны хайгуулын цооног бөгөөд энэхүү БХГ нь Компанийн Монгол Улсад эзэмшиж, үйл ажиллагаа явуулж буй гурван БХГ-ний нэг юм. Цооногийг XX дугаар талбайн Давсан Толгойн ордын анхны туршилтын хэлбэрээр 2010 оны 6 сарын 23-нд өрөмдөж эхэлсэн. Тус цооногийн төлөвлөсөн нийт гүн нь 1440 метр байх юм.

Одоогоор энэхүү давхаргад ямар нэгэн туршилт хийх төлөвлөгөө хийгдээгүй байна. Өрөмдлөгийн ажиллагаа үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд өрөмдлөг дараагийн долоо хоногт эсвэл ойрын арван хоногт багтаан төлөвлөсөн нийт гүнд хүрнэ гэж Компани үзэж байна.

Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Дуглас МакГэй өрөмдлөгийн тайлангийн талаар хэлэхдээ “Доод Зүүнбаян болон Дээд Цагаанцав формацууд нь энэхүү цооногийн хувьд бидний хоёрдогч зорилт гэж тооцогдож байгаа учраас эдгээр илрэлүүд нь бидэнд урам зориг төрүүлж байна. DT-1 цооногийн хувьд Компанийн тавьж буй үндсэн зорилт нь Доод Цагаанцавын формацад нэвтрэх бөгөөд 3D чичирхийллийн судлагааны урьдчилан таамагласнаас 22 метрийн наана Доод Цагаанцавын формацад хүрээд байна. Биднийг үндсэн зорилтдоо хүрэхээс өмнө нүүрсустөрөгч илэрсэн нь сайшаалтай бөгөөд чухал зүйл болж байна гэж бид үзэж байна.

Өрөмдлөгийн ажил маш сайн ахицтай явагдаж байна. Бид цаашдын мэдээллүүдийг тухай бүрт нь хийж байх болно”.

Энэхүү мэдээний техникийн мэдээллийг тус Компаний Хайгуулын Менежер доктор Жэймс Күүган хянаж үзсэн болно. Доктор Күүган Хойд Америк болон олон улсын газрын тосны хайгуул, боловсруулалтын ажлын 29 жилийн туршлагатай газрын тосны геологич хүн. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн.

### **Редакторуудад зориулсан тайлбар:**

#### **Петро Матадын тухай**

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол Улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурван Бүтээгдэхүүн Хуваах Гэрээг (БХГ) дангаараа эзэмшигч байгууллага болно. Үндсэн хөрөнгө нь XX дугаар талбай дээр байгуулсан БХГ

бөгөөд уг талбай нь Монголын зүүн хэсэгт орших 14,250 км<sup>2</sup> газрын тосны талбай юм. Нөгөө хоёр IV, V дугаар талбайнууд нь Монголын нутгийн төв хэсэгт орших ба талбайн нийлбэр хэмжээ нь 73,498 км<sup>2</sup> болно.

Петро Матад нь Аиле эф Ман (Isle of Man)- нд бүртгэлтэй бөгөөд 1483V дугаартай компани юм. Бүртгэгдсэн оффисын хаяг нь Виктори Хаус, Проспект Хилл, Даглас, Аиле эф Ман, Ай ЭМ1 ИИКью болно.

Нэмэлт мэдээллийг дараахь хүмүүстэй холбоо барьж авна уу:

Петроматад Лимитед Дуглас Ж. МакГей – Ерөнхий Гүйцэтгэх Захирал	+976-11-331099
Вестхаус Секюритиз Лимитэд Ричард Бати\Петре Нортон	+44/0/ 20 7601 6100
Банксайд Консалтантс Симон Ротсчайлд\Оливер Уинтерс\Люиси Масон	+44/0/ 20 7367 8888